



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын драмын эрдмийн театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/052/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж

Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсүх

Утас: 261740 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn

Шинэ баланс аудит ХХК-ийн захирал: Б.Мэндбаяр

Утас: 99032649 Цахим хаяг: info@shinebalans-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН
ЗАХИРАЛ Н.НАРАНБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/818
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын драмын эрдмийн театр нь "Театр 2025-2031" оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж хамт олны хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Тайлант хугацаанд Лев Толстойн Анна Каренина жүжиг, Б.Цогнэмэхийн Тэнгэрийн хүү жүжиг, The Love жүжиг, Б.Брехтийн Сычуаны сайн хүн жүжиг, Ц.Балдоржийн Хайрын виз жүжиг, Б.Мөнх-Амьдралын Миний аав супер баатар зэрэг жүжгийг нийт 68 удаа тоглож, 23,500 гаруй үзэгчдэд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон үйл ажиллагааны орлогоор 585,343.5 мянган төгрөгийг

Z:\Yawsan_Bichigl\2025\0225 SNAG-112.Docx

1525000455

төвлөрүүлж, дээд шатны захирагчаас 432,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,017,343.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 617,238.7 мянган төгрөгийг зарцуулж, 400,104.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Б	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,372,438,639.41	1,633,920,680.57
33	АВЛАГА	1,400,902.02	400,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	400,000,000.00
335	Бусад авлага	1,400,902.02	-
3351	Байгууллагаас авах авлага	1,400,902.02	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,371,037,737.39	1,233,920,680.57
351	Түүхий эд материал	5,621,060.00	8,753,346.00
35110	Тусгай зориулалттай материал	5,621,060.00	8,753,346.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	17,847,400.00	17,063,600.00
354	Хангамжийн материал	1,347,569,277.39	1,208,103,734.57
35410	Бичиг хэргийн материал	850,000.00	690,000.00
35420	Аж ахуйн материал	1,326,466,893.39	1,185,284,550.57
35440	Түлш, шатах тослох материал	3,000,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	17,252,384.00	22,129,184.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,927,791,393.82	7,114,663,808.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,927,791,393.82	7,114,663,808.63
392	Биет хөрөнгө	6,489,517,393.82	6,676,389,808.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,281,224,160.00	7,281,224,160.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,201,399,399.64)	(1,436,741,304.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	441,937,000.00	441,937,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(329,437,000.00)	(374,437,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	877,698,886.86	1,197,723,786.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(671,689,268.24)	(552,413,341.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	218,610,706.70	264,534,002.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(138,571,288.86)	(156,581,092.16)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,143,597.00	11,143,597.00
393	Биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
39301	Программ хангамж	2,800,000.00	2,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,800,000.00)	(2,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,300,230,033.23	8,748,584,489.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	596,550.00	596,550.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	596,550.00	596,550.00

413	Өглөг	596,550.00	596,550.00
4136	Бусад өглөг	596,550.00	596,550.00
41361	Байгууллагад төлөх өглөг	596,550.00	596,550.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,299,633,483.23	8,747,987,939.20
51	Засгийн газрын хувь оролцоо	8,299,633,483.23	8,747,987,939.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,588,623,244.49	3,588,623,244.49
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	3,588,623,244.49	3,588,623,244.49
512	Хуримтлагдсан үр дүн	(1,889,425,575.91)	(1,439,581,679.94)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,931,170,313.61)	(1,887,936,135.91)
51220	Тайлант үеийн үр дүн	41,744,737.70	448,354,455.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,600,435,814.65	6,598,946,374.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,300,230,033.23	8,748,584,489.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,023,289,027.27	5,791,621,652.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,300,000.00	431,379,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,300,000.00	431,379,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,300,000.00	431,379,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,300,000.00	431,379,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,020,989,027.27	5,360,242,652.63
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,089,728,500.00	4,342,899,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,089,728,500.00	4,342,899,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	931,260,527.27	1,017,343,452.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,885,600.00	432,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	794,374,927.27	585,343,452.63
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,981,544,289.57	5,343,267,196.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,981,544,289.57	5,343,267,196.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,753,595,708.38	5,059,243,692.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,215,952,340.52	3,121,819,134.43
210101	Үндсэн цалин	1,419,563,098.06	1,855,952,529.28
210102	Нэмэгдэл	398,223,892.66	465,424,067.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	220,408,000.00	529,728,000.00
210104	Урамшуулал	162,151,975.80	250,937,689.92
210105	Гэрээт ажлын хөлс	15,605,374.00	19,776,847.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,831,549.72	390,436,023.21
210201	Тэтгэврийн даатгал	191,561,071.73	266,023,178.61
210202	Тэтгэмжийн даатгал	22,457,335.37	31,555,677.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,609,467.83	22,059,752.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,107,556.40	14,097,357.42
210205	Эрүүл мэндийн даатгал	41,096,118.39	56,700,057.70

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,480,425.69	167,857,436.71
210301	Гэрэл, цахилгаан	64,221,887.63	76,832,800.00
210302	Түлш, халаалт	55,778,999.06	62,245,200.00
210303	Цэвэр, бохир ус	28,479,539.00	28,779,436.71
2104	Хангамж, бараа материалын зардал	117,230,295.85	162,006,122.59
210401	Бичиг хэрэг	7,403,700.00	3,928,600.00
210402	Тээвэр, шатахуун	28,610,000.00	9,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,192,752.00	9,638,546.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,996,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,090,440.00	13,548,540.00
210408	Бараа материал актальсны зардал	61,933,403.85	121,894,435.82
2105	Нормативт зардал	772,000.00	19,225,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	772,000.00	19,225,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,422,377.63	198,491,499.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	88,000.00	550,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,330,000.00	9,900,000.00
210604	Урсгал засвар	100,004,377.63	188,041,499.50
2107	Томилолт, зочны зардал	44,620,500.00	-
210702	Дотоод албан томилолт	44,620,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	363,870,902.70	576,772,917.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,404,574.70	569,948,202.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,032,700.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	535,400.00	525,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,528.00	358,643.00
210807	Газрын төлбөр	530,700.00	3,440,872.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	482,415,316.27	422,635,558.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,121,230.00	52,124,023.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,993,054.00	16,542,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	329,301,032.27	353,969,435.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,948,581.19	284,023,504.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,794,008.00	280,055,494.89

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,484,386.00	48,553,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,849,600.00	206,690,494.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	102,460,022.00	24,811,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,154,573.19	3,968,009.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,154,573.19	3,863,254.02
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт	-	104,755.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>41,744,737.70</u>	<u>448,354,455.97</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,020,989,027.27</u>	<u>5,360,242,652.63</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,020,989,027.27	5,360,242,652.63
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,089,728,500.00	4,342,899,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,089,728,500.00	4,342,899,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	931,260,527.27	1,017,343,452.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,885,600.00	432,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	794,374,927.27	585,343,452.63
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,020,989,027.27</u>	<u>5,360,242,652.63</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,020,989,027.27	5,360,242,652.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,793,040,446.08	4,676,219,148.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,216,725,530.22	3,121,819,134.43
210101	Үндсэн цалин	1,410,390,778.07	1,767,753,966.47
210102	Нэмэгдэл	397,365,129.71	530,379,320.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	219,715,424.94	547,361,530.12
210104	Урамшуулал	158,209,495.37	250,948,530.25
210105	Гэрээт ажлын хөлс	31,044,702.13	25,375,786.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	277,459,262.04	389,035,121.19
210201	Тэтгэврийн даатгал	193,387,347.75	268,416,808.73
210202	Тэтгэмжийн даатгал	21,258,771.67	31,536,067.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,609,467.83	18,333,854.31
210204	Ажилгүйдлийн даатгал	4,107,556.40	14,087,552.49
210205	Эрүүл мэндийн даатгал	41,096,118.39	56,660,838.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,480,425.69	163,857,436.71
210301	Гэрэл, цахилгаан	63,566,281.69	76,832,800.00
210302	Түлш, халаалт	58,993,051.00	58,245,200.00

210303	Цэвэр, бохир ус	25,921,093.00	28,779,436.71
2104	Хангамж, бараа материалын зардал	81,354,792.00	47,483,086.77
210401	Бичиг хэрэг	9,165,000.00	3,806,700.00
210402	Тээвэр, шатахуун	30,510,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,885,752.00	9,638,546.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,886,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,794,040.00	20,151,840.00
2105	Нормативт зардал	17,033,000.00	7,640,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,033,000.00	7,640,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	212,516,805.63	309,003,511.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,810,500.00	56,850,000.00
210602	Тавилга	20,000,000.00	30,292,850.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,580,000.00	28,475,000.00
210604	Урсгал засвар	113,126,305.63	193,385,661.50
2107	Томилолт, зочны зардал	44,620,500.00	-
210702	Дотоод албан томилолт	44,620,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	634,023,509.50	564,121,452.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,557,181.50	557,296,737.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,032,700.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	535,400.00	525,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,528.00	358,643.00
210807	Газрын төлбөр	530,700.00	3,440,872.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,826,621.00	73,259,405.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,720,767.00	49,822,405.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,105,854.00	23,437,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,948,581.19	684,023,504.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,794,008.00	280,055,494.89
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,484,386.00	48,553,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,849,600.00	206,690,494.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	102,460,022.00	24,811,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,154,573.19	403,968,009.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,154,573.19	3,863,254.02

213304	Төвлөрүүлэх шилжүүлэг- Нэмэлт санхүүжилт		400,104,755.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	3,588,623,244.49	6,598,946,374.65	(1,929,680,873.61)	8,257,888,745.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		-
Дахин илэрхийлсэ н үлдэгдэл	3,588,623,244.49	6,598,946,374.65	(1,929,680,873.61)	8,257,888,745.53
Тайлант үеийн үр дүн			41,744,737.70	41,744,737.70
2023 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	3,588,623,244.49	6,598,946,374.65	(1,887,936,135.91)	8,299,633,483.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		-
Дахин илэрхийлсэ н үлдэгдэл	3,588,623,244.49	6,598,946,374.65	(1,887,936,135.91)	8,299,633,483.23
Тайлант үеийн үр дүн			448,354,455.97	448,354,455.97
2024 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	3,588,623,244.49	6,598,946,374.65	(1,439,581,679.94)	8,747,987,939.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,662,881,900.00	4,339,035,945.98	323,845,954.02	93.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,662,881,900.00	4,339,035,945.98	323,845,954.02	93.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,164,350,900.00	4,065,545,451.09	98,805,448.91	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,124,054,200.00	3,121,819,134.43	2,235,065.57	99.9
210101	Үндсэн цалин	1,766,689,700.00	1,767,753,966.47	(1,064,266.47)	100.1
210102	Нэмэгдэл	529,926,100.00	530,379,320.73	(453,220.73)	100.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	546,700,000.00	547,361,530.12	(661,530.12)	100.1
210104	Урамшуулал	251,451,000.00	250,948,530.25	502,469.75	99.8
210105	Гэрээт ажлын хөлс	29,287,400.00	25,375,786.86	3,911,613.14	86.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	390,506,600.00	389,035,121.19	1,471,478.81	99.6
210201	Тэтгэврийн даатгал	268,419,600.00	268,416,808.73	2,791.27	100
210202	Тэтгэмжийн даатгал	31,540,500.00	31,536,067.64	4,432.36	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,335,200.00	18,333,854.31	1,345.69	100
210204	Ажилгүйдлийн даатгал	15,320,200.00	14,087,552.49	1,232,647.51	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	56,891,100.00	56,660,838.02	230,261.98	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,857,500.00	160,857,436.71	63.29	100
210301	Гэрэл, цахилгаан	76,832,800.00	76,832,800.00	-	100
210302	Түлш, халаалт	58,245,200.00	58,245,200.00	-	100
210303	Цэвэр, бохир ус	25,779,500.00	25,779,436.71	63.29	100
2104	Хангамж, бараа материалын зардал	2,109,900.00	2,109,900.00	-	100
210401	Бичиг хэрэг	600,000.00	600,000.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,509,900.00	1,509,900.00	-	100
2105	Нормативт зардал	890,700.00	890,000.00	700.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	890,700.00	890,000.00	700.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	189,508,200.00	189,472,612.00	35,588.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,460,000.00	46,460,000.00	-	100
210602	Тавилга	13,345,700.00	13,314,350.00	31,350.00	99.8

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	28,475,300.00	28,475,000.00	300.00	100
210604	Урсгал засвар	101,227,200.00	101,223,262.00	3,938.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,003,600.00	198,948,731.00	95,054,869.00	67.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,131,200.00	192,124,016.00	95,007,184.00	66.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	525,200.00	525,200.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,200.00	358,643.00	10,557.00	97.1
210807	Газрын төлбөр	3,478,000.00	3,440,872.00	37,128.00	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,420,200.00	2,412,515.76	7,684.24	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,420,200.00	2,412,515.76	7,684.24	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	498,531,000.00	273,490,494.89	225,040,505.11	54.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	498,531,000.00	273,490,494.89	225,040,505.11	54.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,565,600.00	48,553,200.00	12,400.00	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	413,471,800.00	206,690,494.89	206,781,305.11	50.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,493,600.00	18,246,800.00	18,246,800.00	50.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,342,899,200.00	4,339,035,945.98	3,863,254.02	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,342,899,200.00	4,339,035,945.98	3,863,254.02	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,342,899,200.00	4,339,035,945.98	3,863,254.02	99.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	129	116	13	89.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	101	88	13	87.1
620003	Үйлчлэх ажилтан	27	27	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,017,343,452.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,017,343,452.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	610,673,697.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	45,373,186.77
210401	Бичиг хэрэг	-	3,206,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	8,128,646.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,886,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	20,151,840.00
2105	Нормативт зардал	-	6,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	6,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	119,530,899.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,390,000.00
210602	Тавилга	-	16,978,500.00
210604	Урсгал засвар	-	92,162,399.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	365,172,721.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	365,172,721.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	70,846,889.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	47,409,889.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	23,437,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,565,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,565,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,565,000.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт		400,104,755.15
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,017,343,452.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,017,343,452.63
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	432,000,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	585,343,452.63
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 3,813.2 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, нийт 3,813.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тавилга эд хогшил, компьютер, бусад үндсэн хөрөнгө зэрэг нийт 22,320.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Үүнд: Ухаалаг дэлгэц -13,750.0 мянган төгрөг, asus 27 inch monitor -2,570.0 мянган төгрөг, төгөлдөр хуур -6,000.0 мянган төгрөг.	1	22,320.0	-	-	1	22,320.0	-	22,320.0	-	-	-	-
Дүн	1	22,320.0	-	-	1	22,320.0	1	22,320.0	-	-	-	-

дугаар хороонд 12 байр, БЗД-ийн 4 дүгээр хороонд 1 байр, БГД-ийн 8 дугаар хороонд 1 байр нийтдээ 14 байр хүлээлгэж өгснийг бүртгэлд тусгаагүй байна. Эдгээр 14 байрыг Драммын эрдмийн театрын ажилтан, албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэхэд баримтлах журмын дагуу ажилтнуудад түрээслүүлдэг гэх боловч түрээсийн орлогыг нэмэлт орлогын дансанд тайлагнаагүй байна.													
Бараа материалын тайланг батлагдсан маягт, заавар журмын дагуу гаргаагүй, бараа материалын дэлгэрэнгүй болон товчоо тайланг хугацааны дарааллаар бэлтгээгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нормын хувцасны ашиглах хугацаа, ажлаас чөлөөлөгдсөн ажилтны хувцасны үлдэх өртгийг хэрхэн бүртгэх тухай тусгаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	
Цагийн бүртгэлээс зөрүүтэй цалин тооцож олгосон, цагийн бүртгэлийг баталгаажуулаагүй, явсан цагийг бүрэн хөтлөөгүй, ажилласан цагийн нийлбэрийг тооцож гаргаагүй, бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	
Дүн	6	3,813.2	2	3,813.2	1	-	2	-	-	-	-	1	-